

## БАНК МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР

ИНДЕКС: E041203

ЭЛСЭГЧИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН: Бакалавр

СУРАЛЦАХ ЖИЛ: 1.5-2 жил



**ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО.** Салбарын хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ шаардлагад нийцсэн онолын болон судалгаа, шинжилгээний орчин үеийн арга зүй эзэмшсэн, банк, санхүүгийн дэвшилтэд технологийн мэдлэг, чадвартай, олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц банкны мэргэжилтэн, судлаачийг бэлтгэхэд оршино.

**ЗОРИЛТ 01.** Банкны зах зээлийн хөгжлийн чиг хандлага, үндэсний болон олон улсын стандарт шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөрөөр чанартай сургалт явуулна.

**ЗОРИЛТ 02.** Мэргэжлийн болон судлаачийн ёс зүйтэй, мэргэжлийн өндөр ур чадвартай судлаачийг бэлтгэнэ.

### МЭРГЭЖЛИЙН СУУРЬ ХИЧЭЭЛҮҮД

- ❖ Шинжлэх ухааны судалгааны арга зүй
- ❖ Тоон болон чанарын судалгааны арга зүй
- ❖ Ахисан түвшний экономикс
- ❖ Стратегийн менежмент II
- ❖ Англи хэл

### ХӨТӨЛБӨРӨӨР ОЛГОХ МЭДЛЭГ

- ❖ Эрдэм шинжилгээ, судалгааны онол, арга зүйн мэдлэг эзэмшүүлэх
- ❖ Нийгэм, эдийн засаг болон мэдээллийн технологийн мэргэжлийн мэдлэг
- ❖ Мэргэжлийн болон судлаачийн ёс зүйн тухай мэдлэг
- ❖ Санхүүгийн мэргэжлийн онолын болон практик хэрэглээний мэдлэг

### СОНГОН СУДЛАХ ХИЧЭЭЛҮҮД

- ❖ Олон улсын эдийн засаг санхүү II
- ❖ Санхүүгийн эконометрикс II
- ❖ Санхүүгийн гүнзгийрүүлсэн шинжилгээ
- ❖ Банкны нягтлан бодох бүртгэл, хяналт II
- ❖ Мэргэжлийн ёс зүй
- ❖ Санхүүгийн эрсдлийн удирдалаг II
- ❖ Хөрөнгө оруулалтын менежмент II
- ❖ Дижитал санхүү
- ❖ Банкны аудит II
- ❖ Санхүүгийн технологи

### АЖЛЫН БАЙР

- ❖ Аудитор, хянан шалгагч
- ❖ Санхүүгийн байгууллагын эрсдэлийн шинжээч
- ❖ Хөрөнгө зохицуулалтын менежер
- ❖ Зээлийн эдийн засагч
- ❖ Хөрөнгө үнэлгээний менежер, брокер
- ❖ Банкны бусад удирдах албан тушаалууд
- ❖ Судлаач, багш

**ЗОРИЛТ 03.** Орчин үеийн банкны салбарт шаардлагатай технологийн мэдлэгтэй, банкны аудит, хяналт шалгалт, зээлийн болон эрсдэлийн шинжилгээ хийх зэрэг мэргэжлийн ахисан түвшний мэдлэг, чадвартай судлаач, мэргэжилтэн бэлтгэнэ.

**ЗОРИЛТ 04.** Суралцагчдад ахисан түвшний судалгаа, шинжилгээний ажлыг хийх, орчин үеийн судалгааны арга зүйг эзэмшүүлнэ.

### МЭРГЭШҮҮЛЭХ ХИЧЭЭЛҮҮД

- ❖ Удирдлагад зөвлөгөө өгөх үйлчилгээ
- ❖ Ахисан түвшний санхүүгийн менежмент
- ❖ Банкны аудит II
- ❖ Банкны менежмент II
- ❖ Санхүүгийн технологи
- ❖ Мэргэжлийн судалгаа, онолын семинар
- ❖ Магистрын дипломын ажил
- ❖ Магистрын мэргэжлийн дадлага

### МЭРГЭШҮҮЛЭХ ХИЧЭЭЛЭЭР ЭЗЭМШИХ МЭДЛЭГ, УР ЧАДВАР

- ❖ Банк, санхүүгийн технологийг ашиглах
- ❖ Банкны удирдлагын шинжилгээ хийж, шийдвэр гаргах
- ❖ Банкны аудит, шинжилгээ, зээлийн эрсдэлийн үнэлгээ хийх
- ❖ Салбарын хүрээнд тулгамдсан асуудлыг судлах, шинжилгээ хийх, шийдвэр гаргах

### ХӨТӨЛБӨРӨӨР ЭЗЭМШИХ ЧАДВАР

- ❖ Багаар ажиллах ур чадвар, манлайлах, удирдах
- ❖ Харилцааны болон гадаад хэлээр харилцах, ашиглах
- ❖ Тоон өгөгдөл цуглуулах, боловсруулах, шинжлэх, дүгнэх
- ❖ Аливаа асуудлыг системтэй төлөвлөх, харьцуулах, тунгаан боловсруулах

### ХӨТӨЛБӨРИЙН ДАВУУ ТАЛ

Банкны хөтөлбөрөөр суралцсанаар Мандах Их Сургууль болон Швейцар улсын “Open University Switzerland Economics and Technology” сургуулийн хамтарсан ХОС ДИПЛОМ олгох хөтөлбөрт хамрагдах боломжтой. Санхүү, банкны дэвшилтэд технологийн мэдлэг чадвар эзэмшинэ. (Fintech, Digital finance, Big Data)